

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН  
(2018 оны эхний хагас жилийн байдлаар)

**Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар**

2018-06-22

Улаанбаатар хот

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт (зорилтын дугаар)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ (арга хэмжээний дугаар)	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2018 оны зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)	
					Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн, хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7
<b>НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ОНЦГОЙ БОДЛОГО</b>						
<b>Тэргүүлэх зорилт № 1. Эдийн засагт үүссэн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдлыг бууруулж, төлбөрийн тэнцлийн эрсдэлийг багасгах, дунд хугацаанд учирч байгаа өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийг дархлаатай болгох, улмаар эдийн засаг дунд хугацаанд тогтвортой тэлэх бодлогыг баримтална.</b>						
1.4. Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна.	5. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын дүнгийн мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	2016-2020	ТӨБЗГ	-	Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалт сайжрах	<p><b>ТӨБХХ</b></p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын дүнгийн мөрөөр авах арга арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчөөс орон нутгийн өмчид нийт 28,136,741.7 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэх тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Уг тогтоолын төсөл УИХ-д өргөн баригдаж, Эдийн засгийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэгдсэн. УИХ-ын шийдвэр гарсны дараа хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулна.</p> <p>ТӨБЗГ-ын даргын 2017 оны 110, 2018 оны А/08 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг СЯ, БХБЯ, БОАЖЯ, ГХЯ, ЗТХЯ, ТӨБЗГ, ГХГЗЗГ, НӨХГ-ын холбогдох дарга, мэргэжилтнийг оролцуулан байгуулж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. “Хөрөнгийн үнэлгээний талаар авах зарим арга хэмжээ, бэлтгэл ажлыг хангах тухай зөвлөмж”-ийг улсын хэмжээнд мөрдүүлэх арга хэмжээ авч, 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр нийслэл, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга, нягтлан бодогч нарыг хамруулсан семинарыг зохион байгуулав. Хөрөнгийн дахин үнэлгээний бэлтгэл ажлыг хангуулах чиглэлээр Сэлэнгэ, Дархан-Уул, Өмнөговь, Завхан, Говь-Алтай, Дорноговь зэрэг аймагт ажилласан. ТӨБЗГ-ын даргын 2018 оны А/65 дугаар тушаалаар гадаад улс дахь Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшиж, ашиглаж</p>

					<p>байгаа газар болон үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний ажлыг гүйцэтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулав.</p> <p>Мэргэжлийн зөвлөх багийг ажиллуулж, газар, үл хөдлөх хөрөнгийн санхүүгийн тайлагналын зориулалттай үнэлгээ хийх аргачлалын төслийг боловсруулах ажлыг гүйцэтгүүлсэн бөгөөд батлуулахаар Сангийн яаманд хүргүүлэв.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчид хяналт тавьж, өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулах хүрээнд ТӨБЗГ-ын 2018 оны 86 дугаар тогтоолоор “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг баталж, төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг байгууллагын цахим хуудас <a href="http://pcsp.gov.mn/file/3173">http://pcsp.gov.mn/file/3173</a> -д байршуулан олон нийтэд мэдээлэв.</p> <p><b>Өөрийн үнэлгээ:</b> “Үр дүнтэй” – 100%</p> <p><b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, тухайн жилийн зорилтот түвшинд хүрэх боломж бий болсон, удирдлага, зохион байгуулалтын ажлууд хийгдсэн, тодорхой үр дүн гарсан.</p>
	6. Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалт, санхүү, эдийн засгийн байдал баримтын шалгалт хийж, төлбөр зөрчлийг барагдуулж, төсвийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх	2016-2020	ТӨБЗГ	-	<p>39 байгууллагад шалгалт хийх, хуулийн хэрэгжилтийг хангах</p> <p><b>ТӨБХХ</b></p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2016-2017 оны үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх ажлын 2018 оны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөнд нийт 33 хуулийн этгээдэд хяналт шалгалт хийхээр тусгагдсан бөгөөд эхний хагас жилд 10 байгууллагыг шалгалтад хамруулахаас 15 байгууллагад удирдамжийн дагуу шалгалт хийсэн байна. Төрийн өмчит 15 хуулийн этгээдэд хийсэн шалгалтын дүнгээр нийт 157.1 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлж, дүнг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулав. Зөрчил, дутагдлыг арилгах талаар төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх талаар ТӨБЗГ-ын тогтоолоор үүрэг болгож, биелэлтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>Засгийн газрын 2018 оны 8 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өр, авлагыг бууруулах чиглэлээр зөвлөмж өгөв.</p> <p><b>Өөрийн үнэлгээ:</b> “Үр дүнтэй” – 100 %</p> <p><b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрэх тодорхой үр дүн гарсан.</p>
	7. Төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт,	2017-2020	ТӨБЗГ	-	<p>8 байгууллагыг хамруулах,</p> <p><b>ТӨБХХ</b></p> <p>2017 онд төрийн өмчит хуулийн этгээдийн үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийж, шалгалтаар илэрсэн нийт 21.6 тэрбум төгрөгийн зөрчил дутагдлыг арилгаж буй байдалд мониторинг хийсэн бөгөөд</p>

	ашиглалтын байдалд зорилтот болон хэсэгчилсэн мониторинг хийж, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах				өмчид тавих хяналт сайжирч, төсвийн хэмнэлт бий болох	“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК, “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК, “МИАТ” ТӨХК зэрэг 12 хуулийн этгээдийг хамруулав.  <b>Өөрийн үнэлгээ:</b> “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70 %  <b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй боловч тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай.
<b>ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО</b>						
<b>Тэргүүлэх зорилт № 2.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөтөлбөр, “ҮЙЛДВЭРЖИЛТИЙН 21:100” хөтөлбөр, “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” хөтөлбөр, “МАХ, СҮҮНИЙ АНХДУГААР АЯН”-ыг шинээр эхлүүлж, “АТРЫН-Ш АЯН”-ыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.</b>						
2.58. Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.	1. Хөдөө аж ахуй болон үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоодын бэлтгэсэн малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжих ажлыг эрчимжүүлэх	2017-2020	ХХААХҮЯ  (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	5 хоршоог биржийн арилжаанд оролцуулах	<b>БТУХ</b>  Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн спот арилжаа хийж байсан бол форвард арилжаа хийж эхэлсэн. Арьс, шир, улаан буудай, тосны ургамал (рапс) зэрэг бараа, түүхий эдийг биржийн арилжаанд оруулахаар бэлтгэл хийгдэж байна. Хөдөө аж ахуйн 56 хоршоонд биржийн арилжаанд оролцох итгэмжлэл олгосон бөгөөд одоогоор 6 хоршоо арилжаанд оролцоод байна.  <b>Өөрийн үнэлгээ:</b> “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70 %  <b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй боловч тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай.
<b>Тэргүүлэх зорилт № 2.3. Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.</b>						
2.70. Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна.	1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нэгж байгуулах, үйлдвэрийн дэд бүтцийн нарийвчилсан судалгаа, үйлдвэр болон дамжуулах хоолойн газрын асуудлыг шийдвэрлэх	2016-2017	УУХҮЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	-	<b>БТУХ</b>  Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 28 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт орших 150 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авав. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээнд хийгдэх Сайншанд - Газрын тос боловсруулах үйлдвэр чиглэлийн төмөр замын салбар зам, хүнд даацын тусгай зориулалттай авто зам, цахилгаан дамжуулах сүлжээ барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил болон барилгын ажлын гүйцэтгэгчийг туршлага, чадавхитай төрийн өмчит хуулийн этгээдээс сонгон гүйцэтгүүлэхээр Засгийн газрын 2018 оны 21 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн.  Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэлээр “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн дэд

						<p>бүтцийн бүтээн байгуулалт (төмөр зам, авто зам, цахилгаан дамжуулах шугам, үйлдвэрийн талбай)-ыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулан, явц үр дүнгийн талаар танилцуулж байх үүргийг Засгийн газраас холбогдох байгууллагуудад даалгаж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авсан.</p> <p><b>Өөрийн үнэлгээ:</b> “Үр дүнтэй” – 100%</p> <p><b>Тэмдэглэл:</b> Засгийн газраас холбогдох шийдвэр гаргаж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх арга хэмжээ авсан. Тухайн жилийн тавьсан зорилтдоо хүрэх боломжтой.</p>
	2. Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах, төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэлийг хангах	2017	УУХҮЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	-	<p><b>БТУХ</b></p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 02 дугаар тогтоолоор “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэх талаар хэлэлцээ хийхийг ТӨБЗГ-т зөвшөөрсөн. Үүний дагуу холбогдох тооцоо судалгааны үндсэн дээр 250.0 тэрбум хүртэлх төгрөгийн зээлийн гэрээ хийх зөвшөөрлийг ТӨБЗГ-ын 2018 оны 09 дүгээр тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д олгов. Мөн “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТӨБЗГ-ын Ажлын хэсгээс хянасны дагуу баталсан. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 21 дүгээр тогтоолын дагуу Сайншандаас “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” хүртэлх 20 км салаа төмөр замыг “Улаанбаатар төмөр зам” ХНН, хүнд даацын тусгай зориулалтын авто замыг Батлан хамгаалах яам, эрчим хүч дамжуулах агаарын шугамын ажлыг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-иар тус тус гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p><b>Өөрийн үнэлгээ:</b> “Үр дүнтэй” – 100%</p> <p><b>Тэмдэглэл:</b> Засгийн газар, ТӨБЗГ-аас холбогдох шийдвэрийг гаргаж, шаардлагатай арга хэмжээ авсан. Тухайн жилийн тавьсан зорилтдоо хүрч, үр дүн гарах боломжтой.</p>
<b>Тэргүүлэх зорилт № 2.5. Улс орны эдийн засгийн аюулгүй байдлын үндэс болсон эрчим хүчний тогтвортой, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, экспортын чадамжтай болох нөхцөлийг бүрдүүлнэ.</b>						
2.97. Улс орны эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн үндэс болсон суурь салбарын тасралтгүй,	1. Дарханы ДЦС-ыг 35 МВт-аар өргөтгөх	2016-2018	ЭХЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	Ашиглалтад орох	<p><b>БТУХ</b></p> <p>Төслийн шинэ гүйцэтгэгчээр шалгарсан БНХАУ-ын China energy engineering group Tianjin electric power construction Co.Ltd компанигай 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдөр “Төслийн ажлыг дуусгах түлхүүр гардуулах гэрээ”-г байгуулсны дагуу гүйцэтгэгч компанийн 2017 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн төслийн талбайд албан ёсоор ажлаа эхлүүлсэн.</p>

<p>найдартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөх, шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ. /Чойбалсангийн ДЦС, Улаанбаатарын Гуравдугаар ДЦС/</p>						<p>Төслийн ажлын гүйцэтгэлийн хүрээнд, БНХАУ-ын ТВЕА компанид үйлдвэрлэгдэж нийлүүлэгдсэн хүчний 40МВА-ийн трансформаторыг угсарч суурилуулан сүлжээнд залгасан. Трансформатор хэвийн ажиллаж байна.</p> <p>2017 онд Төслийн талбайд дараах барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Турбины өргөтгөлийн барилгын түр ханын суурь;</li> <li>2. Эргэлтийн усны насос станцын тулгуурын 40 хувь;</li> <li>3. Турбины өргөтгөлийн барилгын төмөр хийцийн угсралт;</li> <li>4. Турбины өргөтгөлийн барилгын сэндвич хавтангуудын угсралт;</li> <li>5. Турбины өргөтгөлийн барилгын дээврийн хучилт;</li> <li>6. Хөргөгч цамхагын авлага;</li> <li>7. Цахилгааны хуваарилах байгууламжийн өргөтгөлийн суурь.</li> </ol> <p>Захиалагчийн зүгээс тус гүйцэтгэгч компанид гэрээний дагуу урьдчилгаа төлбөр болгож, 2.1 сая еврогийн төлбөрийг 2017 оны 12 дугаар сард дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг ашиглан төлсөн.</p> <p>2017 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан ажлын графикийн дагуу төслийн ажлыг 2018 онд багтаан дуусгахаар ажиллаж байна. 2019 онд нэмэгдүүлсэн хүчин чадлаар ажиллуулах туршилт хийнэ.</p> <p><b>Өөрийн үнэлгээ:</b> “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70 %</p> <p><b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, тодорхой үр дүнд гарч эхэлсэн, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай. ЗГҮАХ-ийн зорилтот хугацаанд биелэлтийг хангах боломжтой байх төлөв хэвээр байна.</p>
<b>ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО</b>						
<p><b>Тэргүүлэх зорилт № 3.1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг боловсруулж, хүн амыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх эдийн засгийн тооцооллыг бий болгож, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлнэ. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал, хандлагад төлөвшүүлж нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн тусламж үйлчилгээг эрс сайжруулах, Халдварт бус өвчнөөс сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого төлөвлөлтөд урт болон дунд хугацааны хөтөлбөр боловсруулж, чанар хүртээмжийг дээшлүүлнэ. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг хангаж, нийгмийн хамгааллыг сайжруулна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанартай уялдсан эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгоно.</b></p>						
<p>3.1.4. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг үе шаттайгаар 2 дахин</p>	<p>10. Эрүүл мэндийн салбарын дэд бүтэц, тоног төхөөрөмжийн байдалд үнэлгээ хийж, хөрөнгө төлөвлөлтийн</p>	<p>2017-2020</p>	<p>ЭМЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)</p>	<p>-</p>	<p>Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн нийгэм, эдийн</p>	<p><b>ТӨБХХ</b></p> <p>Эрүүл мэндийн яамны шууд хамаарах зорилт, арга хэмжээ. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хамааралгүй заалт. 2017 оны жилийн эцсийн тайланг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд “Үнэлэх боломжгүй” тул цаашид хяналтаас хасуулах санал, шийдвэр гарсан.</p>

нэмэгдүүлнэ.	тогтолцоог бүрдүүлэх				засгийн тооцооны дүн гарах	<b>Өөрийн үнэлгээ: “Үнэлэх боломжгүй”</b> <b>Тэмдэглэл: ТӨБЗГ-т хамаарахгүй байна.</b>
--------------	----------------------	--	--	--	----------------------------	---

**ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

**Тэргүүлэх зорилт № 5.2. Эдийн засаг, бизнесийн эрх зүйн орчны тогтвортой байдлыг чухалчилж, шаардлагатай өөрчлөлт хийхдээ эрх ашиг нь хөндөгдөх этгээдээ заавал асууж, саналыг нь авах соёлыг хэвшүүлэх зарчмыг баримтална.**

5.2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана.	1. Алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, эдийн засгийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	2016-2020	ТӨБЗГ	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, 10.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлого төвлөрүүлэх	<p><b>БТУХ</b></p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан тэнцлийн дүн гарсны дагуу дараах үр дүнгийн мэдээлэл баталгаажив. 2017 онд үйлдвэрлэл санхүүгийн үр ашгийг дээшлүүлж, алдагдалгүй ажиллах зарчмыг баримтлан хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажилласны үр дүнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 71.2 хувь нь ашигтай ажилласан дүнтэй гарсан нь эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавх сайжирсныг харуулж байна.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь 2016 онд 4,571.1 тэрбум төгрөгийн орлоготой, 379.9 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан бол 2017 оны санхүүгийн тайлан тэнцлийн дүнгээр нийт 7,111.2 тэрбум төгрөгийн орлоготой, 5,932.6 тэрбум төгрөгийн зардал гарган 881.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орлого 2,540.1 тэрбум төгрөгөөр буюу 55.6 хувиар, цэвэр ашиг 1,261.1 тэрбум төгрөгөөр буюу 3.3 дахин нэмэгдсэн нь эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавх сайжирсныг илтгэж байна.</p> <p>2016 онд төрийн өмчийн ногдол ашгийн 4.3 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн бол 2017 оны жилийн эцсийн байдлаар ногдол ашгийн 12.6 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 2.9 дахин өссөн үзүүлэлт гарсан. 2018 оны эхний хагас жилд төрийн өмчит 28 хуулийн этгээд төрийн өмчийн 3.6 тэрбум төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлээд байна.</p> <p>Мөн алдагдалтай ажиллаж байгаа, санхүүгийн зохистой харьцаа алдагдсан хуулийн этгээдийн үйл ажиллагааг сайжруулах, өөрчлөн зохион байгуулах зорилгоор ажлын хэсэг томилон ажиллуулж, хуулийн этгээд бүр дээр үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжилтийг хангасан.</p> <p>Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг сайжруулах, удирдлага менежментийг оновчтой болгох үүднээс гүйцэтгэх удирдлагын контрактын гэрээнд заасан үүрэг даалгавар, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн биелэлт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг улирал тутам дүгнэн хугацаатай албан даалгавар өгч гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан болно.</p> <p>Төрийн өмчит зарим хуулийн этгээдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх,</p>
--	--	-----------	-------	---	---	---

					<p>засаглалын тогтолцоог сайжруулах, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох зорилгоор 9 хуулийн этгээдийн талаар санал боловсруулж, Засгийн газарт хүргүүлсэн. Үүний үр дүнд алдагдалтай ажиллаж байсан болон үйл ажиллагаа нь зогссон “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК, “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК, “Монгол тамга” ТӨҮГ, “Монгол тариалан” ТӨҮГ, “Монгол мах” ТӨҮГ-ыг татан буулгах санал боловсруулан Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлсэн.</p> <p><b>Өөрийн үнэлгээ:</b> “Үр дүнтэй” – 100 %</p> <p><b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрэх боломжтой. Удирдлага, зохион байгуулалт сайн, үр дүн гарсан.</p>
	<p>2. Төрийн болон орон нутгийн өмчийн талаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх, компанийн сайн засаглалыг хөгжүүлэх замаар төрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх</p>	2016-2020	ТӨБЗГ	-	<p><b>БТУХ</b></p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр боловсруулсан дараах хууль тогтоомжийг төслийг УИХ-д өргөн барих арга хэмжээг хэрэгжүүлэх шат дараатай ажлыг хийв.</p> <ul style="list-style-type: none"> <li>– Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулалтыг сайжруулах арга хэмжээ авч, УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад тусгах саналыг ЗГХЭГ-т хүргүүлэв;</li> <li>– УИХ-ын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг 2018 оны 03 дугаар сард Засгийн газарт хүргүүлж, Хууль зүй, дотоод хэргийн яамаар үзэл баримтлалыг батлуулах арга хэмжээ авсан. Уг тогтоолын төслийг Засгийн газраас УИХ-д 2018 оны 05 дугаар сард өргөн барьсан;</li> <li>– УИХ-ын “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлсэн бөгөөд Засгийн газраас УИХ-д өргөн баригдаж, Эдийн засгийн Байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэгдээд байна.</li> </ul> <p>Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ыг мөрдөн ажиллаж байна. Уг журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын төслийг боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлээд байна. Дурдсан журмыг хэрэгжүүлэх хүрээнд ТӨБЗГ нь төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудал бүрээр гарах шийдвэрт өгөх саналд удирдамж, заавар өгөх, шаардлагатай гэж үзвэл хэлэлцэх асуудлын талаар Засгийн газраас тодорхой чиглэл аван ажиллаж байна.</p> <p>Өнөөдрийн байдлаар, Төрийн өмчит 38 компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд нийт</p>

					<p>334 гишүүн ажиллаж байгаагаас 230 нь төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүн, 104 нь хараат бус гишүүн юм. Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж байгаа 230 гишүүний 152 нь ЗГХЭГ, яам, агентлаг, орон нутгийн төрийн захиргааны албан хаагч байгаа бол 78 нь ТӨБЗГ-ын албан хаагч ажиллаж байна.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үр ашгийг дээшлүүлэх талаар авах арга хэмжээг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсний дүнд Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 08 дугаар тогтоол батлагдсан. Уг тогтоолыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр ТӨБЗГ-аас 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-1/350 дугаар албан бичгээр төрийн өмчит хуулийн этгээдэд албан даалгавар, чиглэл өгч ажилласан.</p> <p><b>Өөрийн үнэлгээ:</b> “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70 %</p> <p><b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрээгүй боловч тодорхой арга хэмжээ авсан, үр дүн гарах боломж бий болсон, цаашид хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай.</p>
	3. Төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, хувьчлах үндсэн чиглэлийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	2017-2020	ТӨБЗГ	-	<p><b>БТУХ</b></p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үр ашгийг дээшлүүлэх талаар авах арга хэмжээг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсний дүнд Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 08 дугаар тогтоол батлагдсан.</p> <p>Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах үр дүн гарсан:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газарт 2018 оны 03 дугаар сард хүргүүлсэн. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн яам баталсан бөгөөд Засгийн газраас 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ЗГ-1/112 дугаар албан бичгээр Улсын Их Хуралд өргөн барьсан.</li> <li>- Төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийг нэмэгдүүлэх, удирдлага, менежмент, бүтэц зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор алдагдалтай ажиллаж байсан болон үйл ажиллагаа нь зогссон “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК, “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК, “Монгол тамга” ТӨҮГ, “Монгол тариалан” ТӨҮГ, “Монгол мах” ТӨҮГ-ыг тус тус татан</li> </ul>



					буулгасан. Дээр дурдсан Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-1/350 дугаар албан бичгээр төрийн өмчит хуулийн этгээдэд албан даалгавар, чиглэл өгч ажилласан. <b>Өөрийн үнэлгээ:</b> “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70 % <b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрээгүй боловч тодорхой арга хэмжээ авсан, үр дүн гарч байгаа, цаашид хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай.
	4. Төрийн өмчит хуулийн этгээдтэй “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” байгуулж, дүгнэх, төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө, илүүдэлтэй байр талбайг түрээслүүлэн, орлогыг төсөвт төвлөрүүлэх	2016-2020	ТӨБЗГ	-	580.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх <b>ТӨБХХ</b> “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” байгуулж, дүгнэх ажлыг нийслэл, 21 аймгийн төрийн өмчит хуулийн этгээдэд 2018 оны 3 дугаар улиралд багтааж хийхээр төлөвлөгдсөн. Нийт төрийн өмчит 923 хуулийн этгээдийн 2017 оны “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэж, 2018 оны гэрээг байгуулсан бөгөөд дүгнэлтэд гарсан зөрчил дутагдлыг арилгах, цаашид авах арга хэмжээ, хөрөнгийн дахин үнэлгээний ажлаар хамтран ажиллах тухай чиглэл, удирдамжийг ТӨБЗГ-ын 2018 оны А-5/452 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Төрийн өмчийн илүүдэлтэй байр, талбайг түрээслүүлсний орлогоос 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан хяналт тавьж байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар өөрийн ашигтай нийт 19259.05 м.кв талбайг бусдад түрээслэхээр 60 хуулийн этгээдээс санал ирүүлсэн бөгөөд нийт 196 гэрээ болон гэрээний сунгалтыг баталгаажуулан, 280.0 орчим сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. <b>Өөрийн үнэлгээ:</b> “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70 % <b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрээгүй боловч тодорхой үр дүн гарсан, цаашид хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай.
	5. Төсөвт байгууллагуудын саналыг үндэслэн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтгүй автомашиныг нээлттэй	2016-2020	ТӨБЗГ	-	90.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх <b>ТӨБХХ</b> Нээлттэй дуудлагын худалдаагаар 43 байгууллагын нийт 928.07 сая төгрөгийн доод үнэ, 2,917.60 сая төгрөгийн балансын үнэ бүхий 133 автомашиныг худалдахаар төлөвлөснөөс 22 байгууллагын 27 автомашиныг худалдан борлуулж, 79.7 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн. <b>Өөрийн үнэлгээ:</b> “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70 % <b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн

	дуудлагын худалдаагаар худалдаж, орлого төвлөрүүлэх арга хэмжээ авах					<b>хүрээгүй боловч тодорхой үр дүн гарсан, цаашид хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай.</b>
	6. Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад шилжүүлэх замаар хэрэгцээ шаардлагыг хангах зохицуулалт хийх, шаардлага хангахгүй хөрөнгийг акталж устгах, шинээр хөрөнгө худалдан авах асуудлыг оновчтой шийдвэрлэж, зардал хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх	2016-2020	ТӨБЗГ	-	Төсвийн зардал буурах	<p><b>ТӨБХХ</b></p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар 2018 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 209 байгууллагын 15222 нэр төрлийн 47,978.8 сая төгрөгийн хөрөнгийн бүртгэл, хөдөлгөөний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 95 байгууллагын цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон 12901 нэрийн 12,831.86 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан;</li> <li>- 22 байгууллагын 27 нэр төрлийн 2,917.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий эд хөрөнгийг худалдаж, 79.7 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн;</li> <li>- 58 байгууллагын илүүдэлтэй буюу ашигладаггүй 1007 нэрийн 12,396.33 сая төгрөгийн хөрөнгийг хэрэгцээтэй байгууллагад балансаас балансад шилжүүлсэн;</li> <li>- Эрх бүхий байгууллагын баталсан төсөв болон ТӨБЗГ-аас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 13 хуулийн этгээдийн 41 нэр төрлийн нийт 3,531.92 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авах зөвшөөрөл олгосон байна;</li> <li>- 21 байгууллагын 1246 нэр төрлийн 19,139.0 сая төгрөгийн эд хөрөнгийг бүртгэж авсан.</li> </ul> <p>Гарсан шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлэх, хэрэгжүүлэх, тогтоолын биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллав.</p> <p><b>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100 %</b></p> <p><b>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрсэн. Удирдлага, зохион байгуулалт сайн, үр дүн гарсан.</b></p>
	7. Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, төрийн	2016-2020	ТӨБЗГ	-	Зардал хэмнэгдэх	<p><b>ТӨБХХ</b></p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийт 6942 тээврийн хэрэгслийн судалгаа хийж, тоо төрөл, норм нормативыг шинэчлэн тогтоох асуудлаар Засгийн газрын тогтоолын төслийг 2017 онд бэлтгэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй. 2018 оны 1 дүгээр сард ТӨБЗГ-ын А-1/156 дугаар албан бичгээр “Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг дахин хүргүүлсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зарим судалгааг хийх үүрэг даалгавар өгсний дагуу ажиллаж байна. 2018 оны сүүлийн хагас жилд Засгийн газраас тодорхой шийдвэр гаргахаар төлөвлөж байгаа.</p>

	байгууллагуудын дотоод албан хэрэгцээнд ашиглах автомашины тоо, төрөл, нормативыг тогтоох, хяналт тавих замаар төсвийн зардлыг бууруулах арга хэмжээ авах					<p><b>Өөрийн үнэлгээ:</b> “Эрчимжүүлэх шаардлагатай” - 40 %</p> <p><b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, үйл ажиллагааны уялдаа холбоог ханган, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авах шаардлагатай.</p>
	8. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн мэдээллийн системийг боловсронгуй болгох	2016-2020	ТӨБЗГ	-	Хөрөнгийн бүртгэлийг цахимжуулах, төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоог нэмэгдүүлэх	<p><b>ТӨБХХ, МТА</b></p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-ийн хэвийн үйл ажиллагааг хангахын тулд тус системд гарч буй нийтлэг алдааны мэдээлэл, системийг сайжруулах талаар саналыг 21 аймгийн Орон нутгийн өмчийн газраас санал хүлээн авах ажлыг зохион байгуулав. Саналыг үндэслэн системийг хөгжүүлэгч байгууллага болох “G Communication”-той хамтран системд гарч байгаа нийтлэг алдааг засан, системийн гацалтыг багасгаж хурдыг нэмэгдүүлж, хэвийн үйл ажиллагааг хангав.</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-ийг суулгах болон систем дээр ажиллах гарын авлагыг бэлдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим хуудас <a href="http://www.pcsp.gov.mn">www.pcsp.gov.mn</a> -д байршуулав.</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх системийг боловсронгуй болгох” ажлын хүрээнд 2018 оны 01 дүгээр сарын 18-19-ний өдөр Нийслэлийн өмчийн харилцааны газрын 15 мэргэжилтэн, 17 аймгийн Орон нутгийн өмчийн газрын 26 мэргэжилтэн, нийт 41 албан хаагчийг хамруулсан сургалтыг ТӨБЗГ-т зохион байгуулсан.</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем” дэх газар, барилга, нийтийн эзэмшил, тээврийн хэрэгсэл, дуусаагүй барилга, үнэт зүйлс, худаг, зам, гүүрийн мэдээллийн дүүргэлт, санхүүгийн тайлан зэрэгт хяналт тавьж, мониторинг хийсэн. Мониторингийн ажлын чанарыг сайжруулах зорилгоор 2018 оны 3 дугаар сарын 12-18-ны өдрүүдэд 21 аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангийн тулган баталгаажуулалтыг зохион байгуулж, мониторинг хийв.</p> <p><b>Өөрийн үнэлгээ:</b> “Эрчимжүүлэх шаардлагатай” - 40 %</p> <p><b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилт, үр дүнг</p>

						<b>нэмэгдүүлэх шаардлагатай. Хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд чиглэсэн үр дүнтэй алхам хийх, төсөл, тооцоог хийж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох.</b>
5.2.2. Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт” бодлого хэрэгжүүлнэ.	1. Худалдан авах ажиллагаанд олон улсын шилдэг арга туршлагыг нэвтрүүлэн, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг боловсронгуй болгож, цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем, дэд системүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх замаар улсын хэмжээнд ашиглалтад бүрэн оруулах	2016-2020	ТӨБЗГ	-	Цахим гэрээ байгуулах боломж бүрдэх	<p><b>ЗХЗХ, ХААХ, МТА</b></p> <p>ТӨБЗГ нь худалдан авах ажиллагаанд олон улсын шилдэг арга туршлагыг нэвтрүүлэхэд анхаарч, туршлага судлах, энэ чиглэлээр олон улсын мэргэшсэн байгууллагатай хамтран ажиллах боломжийг бий болгоход зорьж байна. Тайлант хугацаанд Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны туршлага, ололтыг судлах чиглэлээр зөвлөхүүдтэй хамтран ажиллав. Тухайлбал, Азийн хөгжлийн банкны зөвлөх тус газарт 1 сарын хугацаанд ажиллаж, 2017 онд зохион байгуулсан чадавх сайруулах сургалтаа батаггах зорилгоор 2018 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр гүйцэтгэх ажлын 1, зөвлөх үйлчилгээний 1 тендер шалгаруулалтын үнэлгээний ажилд арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэв.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт тус байгууллагын төлөөлөл ажиллаж байгаа бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлал батлагдсан, УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх асуудал дэмжигдсэн.</p> <p>“Цахим тендер зохион байгуулах журам”, “Тендерийн жишиг баримт бичиг”-т холбогдох өөрчлөлт оруулах санал боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэв.</p> <p>ТӨБЗГ нь “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” <a href="https://tender.gov.mn">https://tender.gov.mn</a> – ний үйл ажиллагааг улсын хэмжээнд эрхлэн ажиллаж байна. “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ийн дэд системүүдийг хэрэглээнд үе шаттайгаар нэвтрүүлэн ашиглаж байна. Системийн зарим үзүүлэлт, үр дүнг дор танилцуулав:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” <a href="https://tender.gov.mn">https://tender.gov.mn</a> –нд 1366 захиалагч байгууллага бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 467-оор нэмэгдсэн.</li> <li>2. Худалдан авах ажиллагааны “Төлөвлөлтийн дэд систем” дэх улсын хэмжээний төлөвлөгөөнд 2018 оны эхний хагас жилийн байдлаар 19473 төсөл, арга хэмжээ тусгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11775 төсөл, арга хэмжээгээр нэмэгдсэн.</li> <li>3. “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” <a href="https://tender.gov.mn">https://tender.gov.mn</a> –ээр нийт 7217 тендер шалгаруулалтын урилга зарлагдсаны 6218 нь “Цахим тендер шалгаруулалт”-ын урилга байна. Энэ нь нийт урилгын 86.0 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зарласан нийт урилгын тоо 4846-аар нэмэгдэж, цахим тендер шалгаруулалтын хувь 39 хувиар өссөн байна.</li> <li>4. “Цахим шалгалт” дэд системээр эхний хагас жилд 265 шалгалт зохион байгуулагдаж, 4674 иргэн, албан хаагч шалгалт өгсөнөөс 2638 нь тэнцэж,</li> </ol>

					<p>худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ (А3) авсан байна. Улсын хэмжээнд худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшиж, мэргэшсэн, гэрчилгээ бүхий 11765 иргэн бүртгэлтэй байна.</p> <p>5. “Цахим дэлгүүр”-ийн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд одоогоор Засгийн газрын 2017 оны 315 дугаар тогтоолд заасан ерөнхий нэршлийн 17 нэр төрлийн эмийг тус системээр худалдаалж байна.</p> <p>6. “Мэдээлэл солилцооны дэд систем”-ийг төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системтэй холбох талаар “Мэдээлэл солилцох гэрээ” байгуулж, тендер шалгаруулалтад шаардлагатай мэдээллийг төрийн байгууллага хороонд шуурхай солилцох арга хэмжээ авав.</p> <p>7. “Нийлүүлэгчийн удирдлагын систем”-ийг хялбаршуулсан цахим тендер шалгаруулалтын хүрээнд хэрэглээнд нэвтрүүлсэн.</p> <p>8. “Мобайл систем” нь хэрэглээнд нэвтэрч, ухаалаг гар утасны App Store болон Play Store-д байршсан. Уг системийг хэрэглэхэд илүү хялбар болгох зорилгоор сайжруулалтын ажил хийгдэж байна.</p> <p>9. “Цахим гэрээ”-ний дэд систем хэрэглээнд нэвтэрсэн бөгөөд уламжлалт гэрээг цахим системд бүртгэдэг болсон. 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар уг системд 2018 онд тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан 651 гэрээний мэдээлэл бүртгэгдсэн байна.</p> <p><b>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100 %</b></p> <p><b>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрсэн. Удирдлага, зохион байгуулалт сайн, үр дүн гарсан.</b></p>
	2. Төрийн өмчит хуулийн этгээдийн байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг ерөнхий гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлж, баяжуулах	2016-2020	ТӨБЗГ	-	<p>Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, захиалагч, нийлүүлэгч, хэрэглэгчийн уялдаа холбоог сайжруулах</p> <p>Засгийн газрын 2017 оны 315 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг “Цахим дэлгүүр”-ээр дамжуулан улсын хэмжээнд анх удаа зохион байгуулав. Уг худалдан авах ажиллагааг Сангийн сайдын 2017 оны 234 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий гэрээ байгуулах журам”-ын дагуу гүйцэтгэв. Зарим ерөнхий нэршлийн 17 багц эмийн бүтээгдэхүүний тендер шалгаруулалтад эм ханган нийлүүлэгч 10 байгууллага оролцсон бөгөөд тэдгээртэй ерөнхий гэрээ байгуулан ажиллаж байна. 2018 оны эхний хагас жилийн дүнгээр нийт 157 удаагийн захиалга хийгдэж, 1220114 тоо хэмжээтэй эм нийлүүлэгдсэний дүнд 102,124,858.0 төгрөгийн хэмнэлт гарсан байна.</p> <p>Ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Цахим дэлгүүрийн системийг хэрэглээнд нэвтрүүлэх сургалтыг ТӨБЗГ-аас СЯ, ЭМЯ-тай хамтран 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулав. Уг сургалтад АХБ-ны “Улсын эмнэлгүүдийн боломжит үнэтэй эмийн хүртээмжийг сайжруулах” техник тусалцааны (8967-МОН) төслийн дэд ажлын хэсгийн гишүүд, ерөнхий гэрээний</p>

					<p>худалдан авалтыг хэрэгжүүлэх төрөлжсөн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн ЭМГ, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн нийт 58 ажилтныг хамруулав.</p> <p>ТӨБЗГ нь 2018 оны 3 дугаар улиралд багтаан төсвийн урсгал зардлаар худалдан авдаг бараа, бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн судалгааг улсын хэмжээнд хийж, судлагааны үр дүнд 2019 онд ерөнхий гэрээгээр худалдан авах боломжтой бараа, бүтээгдэхүүний нэр төрлийг тодорхойлохоор төлөвлөсөн.</p> <p><b>Өөрийн үнэлгээ:</b> “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70 %</p> <p><b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрээгүй боловч тодорхой үр дүн гарсан, цаашид хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай.</p>
--	--	--	--	--	--

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (ЗГҮАХХАХТ)-нд тусгагдсан арга хэмжээ (заалт) бүрийн хэрэгжилт, үр дүнгээр тайлагнав. Нийт 4 бүлэг бодлогын хүрээний 6 тэргүүлэх зорилтод хамаарах **18** арга хэмжээг ТӨБЗГ-ын нэр дээр хяналтад авч, хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргав.

Үнэлгээний дүнгийн товч танилцуулга:

ЗГҮАХХАХТ-нд тусгагдсан арга хэмжээ (заалт)-ний тоо – **18**; Үүнээс:

“Үр дүнтэй” буюу 100 % - 7;

“Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 % - 8 арга хэмжээ;

“Эрчимжүүлэх шаардлагатай” - 40 % - 2 арга хэмжээ;

“Үр дүнгүй” буюу 0 % - 0;

“Үнэлэх боломжгүй” – 1 арга хэмжээ.

ЗГҮАХХАХТ төлөвлөгөөний тухайн жилийн зорилтот түвшингийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ (хувь) – **78.8** %.

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

ТАЙЛАНГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ